

САЙД, ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
“А” АНГИЛЛЫН ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2022 оны 03 дугаар улирал)

2022 оны 11 дүгээр сарын 16

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Сайд, Төрийн нарийн бичгийн даргын “А” ангиллын тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан ажлын хэсгийн тайлан, томилолтын илтгэх хуудас, томилолтоор ажилласан тайланг холбогдох тушаал, удирдамжтай тулган шалгах, тайлан мэдээнд дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглаж, цуглуулсан нотлох баримт, хяналт-шинжилгээ, үнэлгээний дунд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2022 оны 03 дугаар улирлын байдлаар Сайд, Төрийн нарийн бичгийн даргын “А” ангиллын ажлын хэсэг байгуулсан тушаалын хэрэгжилт дунджаар 84.7 хувь, гадаад, дотоод албан томилолтын илтгэх хуудас, томилолтоор ажилласан тайлан танилцуулсан байдал дунджаар 37.9 хувийн үзүүлэлттэй байна.

Сайд, Төрийн нарийн бичгийн даргын “А” ангиллын тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хэрэгжилтийг 2022 оны 03 дугаар улирлын байдлаар хүснэгтээр үзүүлбэл:

№	Ажлын хэсэг байгуулсан тушаал	Тушаалын тоо	Биелэлт хувиар				Хугацаа боловсруулсан белоогүй	Дундаж хувь
			100	70	30	0		
1	Сайдын “А” тушаал	10	5	3	-	-	2	88.7
2	ТНБД-ын “А” тушаал	14	8	1	1	1	3	81.8
Нийт		24	13	4	1	1	5	84.7

Тайлант хугацаанд ажлын хэсэг байгуулсан 28 тушаал гарснаас 13 ажлын хэсгийн ажил бүрэн хийгдэж дууссан ба 5 ажлын хэсгийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, 4 ажлын хэсгийн ажлыг үнэлэх боломжгүй байна.

Гадаад, дотоод албан томилолтын илтгэх хуудас, томилолтоор ажилласан тайланг холбогдох журмын дагуу танилцуулсан байдлыг 2022 оны 03 дугаар улирлын байдлаар хүснэгтээр үзүүлбэл:

№	Томилолтын тушаал	Тушаалын тоо	Томилолтын илтгэх хуудас бичсэн	Томилолтын илтгэх хуудас танилцуулсан	Томилолтоор ажилласан тайлан бичсэн	Илтгэх хуудас, тайлан байхгүй	Хэрэгжилтийн хувь
1	Сайдын "А" тушаал (гадаад албан томилолт)	7	6	6	6	1	85.7%
2	ТНБД-ын "А" тушаал (гадаад, дотоод албан томилолт)	22	2	1	5	17	22.7%
Дүн		29	8	7	11	18	37.9%

Гадаад албан томилолтын 31 тушаал гарснаас 2 гадаад томилолт цуцлагдаж 8 илтгэх хуудас, томилолтоор ажилласан 11 тайланг Гадаад хамтын ажиллагааны хэлтэст ирүүлсэн байна. Дотоод албан томилолтын илтгэх хуудас, томилолтоор ажилласан тайлан Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлээгүй байна.

Дөрөв. Дүгнэлт

1. 2022 оны 03 дугаар улирлын байдлаар Сайд, Төрийн нарийн бичгийн даргын "А" тушаалаар ажлын хэсэг байгуулсан тушаалын хэрэгжилтийг "хэрэгжих шатанд", томилолтын тушаалын илтгэх хуудас, томилолтоор ажилласан тайлан танилцуулсан байдлыг "хэрэгжилт хангалтгүй" гэж дүгнэлээ.
2. Ихэнх ажлын хэсэг тушаалд заасан хугацааг баримталж ажиллаагүй байна.
3. Хяналт тавих ажлын явцад 23 ажлын хэсэг тайлан ирүүлэхээс 3 ажлын хэсэг тайлан ирүүлж, 20 ажлын хэсэг тайлан гаргаагүй байна.
4. Албан томилолтоор ажиллуулах тушаалд Төрийн захиргааны удирдлагын газарт холбогдох журмын дагуу 5 хоногийн дотор томилолтын илтгэх хуудас, томилолтоор ажилласан тайлан танилцуулахыг томилолтоор ажиллах албан хаагчид үүрэг болгож байгаа ч мөрдөж ажиллаагүй байна.
5. Хэрэгжиж дууссан төслийн эд хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх асуудлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандаж зөвшөөрөл авч шийдвэрлэх байтал эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр ТНБД-ын 2022 оны А/09, А/21 дүгээр тушаалаар ашиглагч байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.
6. ТНБД-ын 2022 оны А/27 дугаар тушаалаар "Эд хөрөнгийн тооллогын комисс" томилоходоо хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, тайлагналын асуудлыг хариуцаж байгаа, мөн тооллого хийх бэлтгэл ажлыг хангах үүрэгтэй Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн албан хаагчдыг тооллогын комиссын дарга, гишүүн, нарийн бичгийн даргаар томилсон байна.

Тав. Зөвлөмж

1. Ажлын хэсгийн тайлан, үр дүн, томилолтын илтгэх хуудас, томилолтоор ажилласан тайланг хугацаанд нь танилцуулсан эсэхэд Төрийн захиргааны удирдлагын газар хяналт тавьж ажиллах, бүртгэлжүүлэх, хариуцлага хяналтын тогтолцоог сайжруулах;
2. Ажлын хэсэг удирдамжид заасан ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэж тайланг удирдлагад танилцуулж байх;
3. “Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага” MNS 5140-2:2021 стандартыг мөрдөж ажлын хэсгийн тайланд ажлын хэсгийн ахлагч, гишүүд, нарийн бичгийн дарга нар бүгд гарын үсэг зурах, баримт бичгийг цаасны нэг талд бичиж хэвлэх;
4. Эд хөрөнгийн тооллогын комисс байгуулахдаа эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, тайлагналыг хариуцсан албан хаагчдаас өөр албан хаагчдыг комиссын бүрэлдэхүүнээр томилж, тооллого хийлгэх;
5. Хугацаа: 12 дугаар сарын 01-ний дотор биелэлт гаргах.

Дэлгэрэнгүй хэрэгжилтийг хавсаргав. Үүнд:

Хавсралт 1. Сайдын “А” тушаалын хэрэгжилт /ажлын хэсэг/

Хавсралт 2. ТНБД-ын “А” тушаалын хэрэгжилт /ажлын хэсэг/

Хавсралт 3. Сайдын “А” тушаалын хэрэгжилт /томилолт/

Хавсралт 4. ТНБД-ын “А” тушаалын хэрэгжилт /томилолт/

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗАР**

---оо---

Хавсралт 1

САЙДЫН "А" АНГИЛЛЫН ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТ /АЖЛЫН ХЭСЭГ/
(2022 оны 03 дугаар улирлын байдаар)

2022 оны 11 дүгээр сарын 16

Улаанбаатар хот

№	Огноо	Дугаар	Ажлын хэсэг	Ажлын хэсгийн тайлан гарсан эсэх (Тийм-1, Үгүй-0)	Хэрэгжилт		Үнэлгээ
					1	2	
3	4	5	6	7			
1	2022.02.01	A/05	<p>Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p> <p>2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор сайдын зөвлөлийн хуралд танилцуулах</p> <p>Ажлын хэсгийн ахлагч Б.Билэгдэмбэрэл Нарийн бичгийн дарга М.Оролзод, З.Сэргээн</p>	0	<p>Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр тэргүүлэгч орнууд болох АНУ, Япон, БНСҮ, Гүрж, Унгар, ОХУ, Эстони, Европын холбооны кибер аюулгүй байдлын стратегийг судалж, кибер аюулгүй байдлыг хангах гол хүчин зүйлүүдийг тодорхойлсон. Мөн ОУЦХБ-аас гаргасан Кибер аюулгүй байдлын судалгааны тайлан болон манай улсын кибер аюулгүй байдлыг хангах өнөөгийн нехцэл байдлын судалгаанд үндэслэн асуудлуудыг тодорхойлсон. Дээрх судалгаанд тулгуурлан Монгол улсын кибер аюулгүй байдлын үндэсний стратегийн төслийг 5 зорилт, 41 үйл ажиллагаатайгаар боловсруулсан. Зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, шаардагдах зардлын тооцоог гаргасан. Мөн "Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги батлах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулсан. Засгийн газрын хуралдааны журмын 6.1-т заасны дагуу Засгийн газрын бүх гишүүдээс санал авахаар сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/947 дугаар албан бичгээр, шинээр сайдууд томилогдсонтой холбогдуулан дахин санал авах тухай 2022 оны 01/2027 дугаар албан бичгээр хүргүүлэн санал авч байна.</p>	70%	
2	2022.02.08	A/06	<p>Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсэг</p> <p>2022 оны 01 дүгээр улиралд багтаан Сайдын зөвлөлийн хуралд танилцуулах</p>	1	<p>Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2022 оны 01 дүгээр улирлын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж тайланг тус байгууллагад Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагчийн 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01/506 дугаар албан бичгээр Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ- хүргүүлсэн.</p>	100%	

			Ажлын хэсгийн ахлагч Д.Жавхлан Нарийн бичгийн дарга А.Түвшинзаяа			
3	2022.03.09	A/11	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаар баримтлах бодлогын чиглэлийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор сайдын зөвлөлийн хуралд танилцуулах Ажлын хэсгийн ахлагч З.Гантоогоо Нарийн бичгийн дарга Н.Чулуунчимэг	0	Бодлогын чиглэлийг боловсруулан санал авахаар төслийг харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч 650 байгууллагад ТНБД-ын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 3/895 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Ирүүлсэн саналыг нэгтгэж тусгасан. 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр үүрэн холбооны оператор компаниуд, ХХЗХ, Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК зэрэг байгууллагууд оролцсон хэлэлцүүлцэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үр дүнд гарсан саналуудыг төсөлд тусгасан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн A/73 дугаар тушаалаар Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сантай холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэхэд үүсээд буй асуудлыг шийдвэрлэх талаар холбогдох хууль, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах ажлын хэсэг байгуулгадсан. Тус ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмж гарсны дараа батлуулахаар хүлээгдэж байна.	70%
4	2022.03.14	A/13	Гамшгийн үеийн харилцаа холбооны бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор сайдын зөвлөлийн хуралд танилцуулах Ажлын хэсгийн ахлагч З.Гантоогоо Нарийн бичгийн дарга Б.Тунгалаг	0	Төлөвлөгөөг төслөөр боловсруулж, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч 25 байгууллагаас санал авахаар сайдын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 03/1742 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 20 байгууллага санаалаа ирүүлсэн. 10 дугаар сарын 13-ний өдөр Олон улсын цахилгаан холбооны байгууллагуудын зөвлөхүүдтэй цахим уулзалттыг зохион байгуулж санал солилцсон. Төлөвлөгөөг боловсруулж дууссан ба хавсралт хэсгийн мэдээлэл цуглуулах ажил хийгдэж байна.	70%
5	2022.03.24	A/15	Сансар судлал, сансрын технологийг оюутан залусын дунд дэлгэрүүлэх, хиймэл дагуулын техник, технологийг эзэмшүүлэх, олон нийтэд таниуulan сурталчлах, тус салбарын хүний нөөцийг бэлтгэн чадавхжуулах зорилго бүхий "Кансат-2022" тэмцээний зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсэг 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Сайдын зөвлөлийн хуралд танилцуулах Ажлын хэсгийн ахлагч З.Гантоогоо Нарийн бичгийн дарга Б.Заяабаяр	0	Тэмцээний бэлтгэл ажлын хүрээнд хиймэл дагуул бүтээх төслийн дараалалтай адилханаар чиглүүлэх сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тэмцээнд оролцогч 15 багийн их, дээд, сургууль, коллежид сургуулиудаас нь дэмжлэг үзүүлэх талаар ТНБД-ын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 03/544 дүгээр албан бичиг хүргүүлсэн. Олон нийтэд хүргэх зорилгоор "Рэд фильм" студитэй гэрээ байгуулж ТНБД Б.Болор-Эрдэнэ, сансрын нисэг Ж.Гуррагчaa, ШУА-ийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн захирад С.Дэмбэрэл, МОСТА ТББ-ийн тэргүүн Д.Эрдэнэбаатар, ивээн тэтгэгчээр оролцсон Монголсат нэтворкс ХХК-ийн гүйцэтгэх захирад Ц.Дөлгөөнтэнгис, оролцогч багуудын төлөөлөл оролцсон ярилцлага хийж хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр мэдээлсэн. Тэмцээний талбай зохион байгуулалтыг хангаж Хас майхан ХХК, Мөнхийн хүндлэл ХХК, Лед Айди ХХК-тай түрээсийн гэрээ хийж ажилласан. Сайн дурын ажилтнуудын болон зохион байгуулагчдын хувцсыг нэгдсэн байдлаар захиалж, анноанс, цом, замын тэмдгийн эхийг хэвлэлийн газруудаар захиалж хийлгэсэн. Тэмцээнийг 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдөр амжилттай зохион байгуулсан.	100%

6	2022.05.02	A/19	<p>Цахим орчин дахь хүүхдийн эрх зөрчигдөх, цахим зөрчил, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсэг</p> <p>2023 оны 01 дүгээр улиралд багтаан танилцуулах</p> <p>Ажлын хэсгийн ахлагч ТНБД Б.Болор-Эрдэнэ Нарийн бичгийн дарга А.Золзаяа</p>	-	<p>Мета групптэй хамтын ажиллагааны хүрээнд цахим орчны хүүхэд хамгааллын чиглэлээр зохисгүй агуулгатай, хууль зөрчсөн мэдээ, мэдээлэл, контентыг устгах, хязгаарлах зохицуулалтыг хийж, иргэдийн тоон бичиг үсгийн боловсролын түвшинг нэмэгдүүлэх, цаашдын алхмуудаа тодорхойлох зорилготой We think Digital Summit арга хэмжээг хамтран зохион байгуулсан. "Цахим орчны хүүхэд хамгаалал" фэйсбүүк хуудсаар дамжуулан хүүхэд, эцэг эх, багш наарт зориулан цахим орчинд эрхээ хэрхэн хамгаалах, техник технологийн зохистой хэрэглээний талаар зөвлөмж мэдээллийг тухай бүр хүргэж байна. ЮНЕСКО-гоос жил бүрийн 10 дугаар сарын сүүлийн долоо хоногийг "ХММСБ-ын долоо хоног" болгон зарласантай холбогдуулан хүүхэд залуучууд руу чиглэсэн цахим аян өрнүүлэх ажлын хүрээнд 10 дугаар сарын 28-наас 30-ны өдрүүдэд "Үндэсний ХММСБ-ын долоо хоног-Залуучуудын хакатон" арга хэмжээг хамтран зохион байгуулсан. ЦХХХЯ, ХНХЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, ГБХЗХГ-тай хамтран "Мэдээлэл, технологийн салбар дахь охидын манлайлал" сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг улсын хэмжээнд зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт цахимаар болон танхимаар 200 гаран охид оролцсон. Цахим орчны хүүхэд хамгааллын чиглэлээр 10 төрлийн 8,0 мянган ширхэг постерыг хүүхдүүдэд ерөнхий боловсролын сургуулиудаар дамжуулан Боловсролын ерөнхий газартай хамтран хүргүүлж, богино хэмжээний контент, мэдээллийг бэлтгэж яамны фэйсбүүк цахим хуудсаар түгээж, ЦЕГ, ХХЗХ, интернет үйлчилгээ эрхлэгчдийн төлөөлөл болох ДДШ, Юнивишин компаниудтай 09 дүгээр сарын 29-ний өдөр уулзалт зохион байгуулсан. Үүрэн холбооны оператор компаниудын дугаарыг бүрэн бүртгэлжүүлэх ажил 85 хувьтай, хүүхдэд олгож байгаа дугаарт эцэг, эхийн мэдээллийг давхар бүртгэж байна. ХНХЯ-наас боловсруулсан хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон дагалдах хуулийн төслүүдэд санал хүргүүлсэн. Хүүхдийн зохисгүй агуулгаас хамгаалах радио телевизийн дүрэм, тус дүрмийн орон тооны бус зөвлөлийг танилцуулах шторк бэлтгэн радио телевизүүдээр 10 дугаар сард нэвтрүүлсэн. Стандартчилал хэмжил зүйн газрын даргын 2020 оны С/40 дугаар тушаалаар батлагдсан кино, контентын настын ангиллын стандартыг мөрдүүлэх ажлыг ХХЗХ хийж байна.</p>	100%
7	2022.05.05	A/20	<p>Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сантай холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэхэд үүсээд буй асуудлыг шийдвэрлэх талаар холбогдох хууль, журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p> <p>2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Сайдын зөвлөлийн хуралдаанаар танилцуулах</p> <p>Ажлын хэсгийн ахлагч З.Гантоогоо</p>	0	<p>БНҮҮС-ийн зориулалт Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хуульд өөр өөрөөр тусгасан зөрчлийг арилгах, санд хөрөнгө төвлөрүүлэх хуулийн этгээдийн хамрах хүрээг зөвхөн харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч болгож багасгах, төвлөрүүлэх хөрөнгийн хувь хэмжээг өөрчилж хуулийн өмнөх зохицуулалтыг хэвээр мөрдөх, хөрөнгө төвлөрүүлэх, төвлөрүүлсэн хөрөнгийг буцаан зарцуулах, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт тогтмол хяналт тавих шаардлага байгаа учир ажлын албатай болгох гэсэн 4 үндсэн чиглэлийн хүрээнд хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан бөгөөд хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог боловсруулж удирдлагад танилцуулсан. Сайдын 2022 оны 11</p>	-

			Нарийн бичгийн дарга Б.Солонго		дүгээр сарын 07-ны өдрийн A/73 дугаар тушаалаар БНҮҮС-тай холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэхэд үүсээд буй асуудлыг шийдвэрлэх талаар хууль, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах ажлын хэсгийг шинээр байгуулсан тул тус ажлын хэсэг цаашид ажиллахгүй болсон. Үнэлэх боломжгүй.	
8	2022.05.20	A/25	Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө тухайн үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлтийг боловсруулах байнгын ажиллагаатай ажлын хэсэг Улирал тутам танилцуулах Ажлын хэсгийн ахлагч Б.Билэгдэмбэрэл Нарийн бичгийн дарга Б.Лхагвадолгор	0	ЦХХХ-ны сайдын 2022 оны A/18 дугаар тушаалаар батлагдсан "Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг хэрэгжилтийг хангуулах зорилгоор териин захиргааны төв байгууллагуудад албан бичиг хүргүүлсэн. Энэ дагуу териин захиргааны 9 байгууллага албан бичиг ирүүлсэн боловч систем үүсгээгүй, журамд заасан шаардлагыг хангaaгүй тул дүгнэлт, зөвлөмж гаргаагүй. Журамд заасан мэйл хаягаар Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн систем үүсгэх ажилд дүгнэлт, зөвлөмж гаргуулахаар мэдээлээ ирүүлсний хянаж дүгнэлт зөвлөмжийг боловсруулж хүргүүлсэн. Журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Ерөнхий сайдын "Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай" албан даалгаврын төсөл боловсруулж 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр гарсан. Мөн "Зөвлөмж, дүгнэлт гаргуулах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж яамдаас санал авахаар сайдын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 01/1733 дугаар албан бичигийг хүргүүлсэн. Ирсэн саналыг нэгтгэж байна. И-Монгол УТҮГ-ын бүтэц, орон too шинэчлэн батлагдаж дүгнэлт зөвлөмж гаргах чиг үүргийг хариуцан ажиллахаар болсон. Ажлын хэсэг боловсруулсан дүгнэлт зөвлөмжид хяналт тавьж ажиллана.	100%
9	2022.06.23	A/29	Дэлхийн радио холбооны их хурал (WRC-23), түүний бэлтгэл хурлуудад оруулах Монгол Улсын саналыг нэгтгэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Ажлын хэсгийн ажлын удирдамжийн дагуу гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулах Ажлын хэсгийн ахлагч Ц.Гантэгс Нарийн бичгийн дарга С.Онончимэг	-	Териин нарийн бичгийн даргаар "Дэлхийн радио холбооны их хурал (WRC-23)-д бэлтгэх ажлын хэсгийн төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	-
10	2022.07.06	A/36	Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын жендерийн стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах үүрэг бүхий ажлын хэсэг Төлөвлөгөөг 2022 оны 04 дүгээр улиралд багтаан боловсруулж батлуулах Ажлын хэсгийн ахлагч З.Гантоогоо Нарийн бичгийн дарга Д.Сэлэнгэ	-	Жендерийн талаар нэгдсэн ойлголт өгөх сургалтыг 07 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад харьяа, салбар байгууллагын 48 албан хаагч хамрагдсан. Ганцаарчилсан болон бүлгийн уулзалтыг хуваарийн дагуу зохион байгуулсан. Салбар дахь жендерийн онцлог хэрэгцээ шаардлагыг тодруулах судалгааг албан хаагчдаас 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 15-ны өдрийн хооронд цахимаар авсан. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	-

11	2022.07.22	A/37	<p>Шуудангийн маркийн улсын фондын хадгалалт, хамгаалалтын байдалд үзлэг, шалгалт хийх, фондын эрхлэгчийн ажлыг хүлээнцүүлэх, фондод 2021-2022 онд шинээр хэвлэгдсэн гарсан шуудангийн маркаас шилжүүлэн баяжилт хийх үүрэг бүхий комисс</p> <p>2022 оны 09 дүгээр сарын 12-оос 20-ны өдрүүдэд зохион байгуулж, холбогдох тайланг нэгжийн удирдлагад танилцуулах</p> <p>Комиссын ахлагч М.Солонго Нарийн бичгийн дарга Н.Оюун-Эрдэнэ</p>	1	<p>Засгийн газрын 1995 оны 164 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол шуудангийн улсын фонд бүрдүүлэх журам"-ын дагуу 2021, 2022 онд шинээр хэвлэгдэн гарсан улс төрийн сэдэвтэй 100 ширхэг марк, чөлөөт сэдэвтэй 300 ширхэг маркаар баяжуулалт хийсэн. Фондын эрхлэгч Ш.Долгорсүрэн тэтгэвэрт гарах болсон тул М.Сэлэнгэд ажлыг нь хүлээлгэж егсэн. Мөн фондын хадгалалт, хамгаалалтын байдалд үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн.</p>	100%
Дундаж үнэлгээ			2			88.7%

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН "А" ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТ /АЖЛЫН ХЭСЭГ/
(2022 оны 03 дугаар улирлын байдлаар)

2022 оны 11 дүгээр сарын 16

Улаанбаатар хот

№	Огноо	Дугаар	Ажлын хэсэг	Ажлын хэсгийн тайлан гарсан эсэх (Тийм-1,Үүй-0)	Хэрэгжилт	Үнэлгээ
1	2	3	4	5	6	7
1	2022.01.07	A/02	ЦХХХЯ-ны зохион байгуулалтын бүтцийн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Ажлын хэсгийн үр дүнг 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор удирдлагуудад танилцуулах Ажлын хэсгийн ахлахгч Д.Жавхлан Нарийн бичгийн дарга Б.Солонго	0	Албан тушаал бүрээр албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан ТНБД-ын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03/28 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 31-ний хуралдаанаар тус яамны төрийн захиргааны 78 албан тушаалын тодорхойлолтыг хянан хэлэлцэж батлах зөвшөөрлийг олгосон. Зөвшөөрлийн дагуу ТНБД-ын 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн A/05, A/06, A/07, A/08 дугаар тушаалаар "Цахим хөгжил, харилцаа холбооны яамны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолт"-ыг тус тус баталсан.	100%
2	2022.02.21	A/09	"Үйлчилгээний нэгдсэн төвийн мэдээллийн систем" программ хангамж хөгжүүлэх төсөл: Цахим үйлчилгээний систем /Front-end/-ийг хөгжүүлэх ХХМТГ/20192003 Багц-1, Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн мобайл платформ хөгжүүлэх ХХМТГ/2020010, Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн нэмэлт хөгжүүлэлт ХХМТГ/202106030 тоот төслийн гэрээний дагуу хийгдсэн ажлыг хүлээн авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий комисс, хүлээн авсан эд хөрөнгийг "И-Монгол академи" УТҮГ-т актаар хүлээлгэн өгөх Комиссын ажилласан тайланг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний дотор багтаан танилцуулах Комиссын ахлагч Б.Билэгдэмбэрэл Нарийн бичгийн дарга Д.Батчимэг	0	"Үйлчилгээний нэгдсэн төвийн мэдээллийн систем" программ хангамж хөгжүүлэх төсөл: Цахим үйлчилгээний систем /Front-end/-ийг хөгжүүлэх ХХМТГ/20192003 Багц-1, Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн мобайл платформ хөгжүүлэх ХХМТГ/2020010, Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн нэмэлт хөгжүүлэлт ХХМТГ/202106030 тоот төслийн гэрээний дагуу хийгдсэн ажлыг хүлээн авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэг Аствишн ХХК-аас хүлээлцэх актаар хүлээн авсан байна	100%

3	2022.02.23	A/10	<p>Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр ЦХХСайд болон аймгуудын Засаг дарга нарын хооронд 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан гэрээний хэрэгжилтийн хүрээнд тус аймгийн хүн амд үзүүлэх төрийн цахим үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх, орон нутгийн хөгжилд харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, цахим шилжилт хийхэд дэмжлэг үзүүлэх комисс</p> <p>Комиссын ажлын тайланг сар бүр удирдлагад танилцуулах</p> <p>Комиссын ахлагч Б.Билэгдэмбэрэл Нарийн бичгийн дарга Б.Лхагвадолгор</p>	0	<p>"Цахим үндэстэн" бодлогын баримт бичгийн хүрээнд "Цахим аймаг" хөтөлбөрийг боловсруулах зөвлөмж боловсруулан ТНБД-ын 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 03/241 дүгээр албан бичгээр аймгуудад хүргүүлсэн. "Цахим жишиг аймаг" хөтөлбөрийг хөдөө орон нутагт танилцуулах арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Булган, Хөвсгөл аймагт зохион байгуулсан. Мөн 21 аймагт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, төрийн үйлчилгээний нэгдсэн системээр үзүүлэх олон шатлалт төрийн үйлчилгээг дахин загварчлах, сургалт, нэвтрүүлэлтийн чиглэлээр ажилласан. "Дижитал Баянхонгор" арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд Баянхонгор аймагт 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдөр үүрэн холбооны оператор компаниуд, харилцаа холбооны төрийн өмчтэй компаниудтай хамтран ажилласан. Аймгуудын засаг дарга нартай хийсэн хамтран ажиллах гэрээний биелэлтийг хангуулах ажлын хүрээнд ТНБД-ын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 03/1009 дүгээр албан бичгийг 21 аймаг, нийслэлд хүргүүлсэн.</p>	70%
4	2022.03.14	A/18	<p>УИХ-ын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.18, 7.5.7 дахь зорилт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 8 дугаар тэмдэглэлийн I.3-ын 1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд "Төрийн албан хаагчдын цахим үр чадварыг хөгжүүлэх хөтөлбөр, агуулга боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэг</p> <p>Үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үр дүнг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулах</p> <p>Ажлын хэсгийн дарга Л.Энхбат Нарийн бичгийн дарга Л.Нармандах, Э.Оюунгоо</p>	0	<p>Төрийн албан хаагчдын мэдээллийн технологи ашиглах чадавхын олон улсын туршлага, тогтолцоог судалж, төрийн албан хаагчдын мэдээллийн технологи ашиглах чадварыг хөгжүүлэх 6 модуль бүхий 36 хичээлийн агуулгатай сургалтын хөтөлбөр, сургалт зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулж И-Монгол академи УТҮГ-ын захирлын 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн A/42 дугаар тушаалаар баталсан.</p>	100%
5	2022.03.23	A/21	<p>"Үйлчилгээний нэгдсэн төвийн мэдээллийн систем" программ хангаж хөгжүүлэх төсөл: ХХМТГ/20192003 Багц-2 Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/-ийг хөгжүүлэх төслийн гэрээний дагуу хийгдсэн ажлыг хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий комисс, хүлээн авсан эд хөрөнгийг "И-Монгол академи" УТҮГ-т актаар хүлээлгэн өгөх</p>	0	<p>Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/-ийг хөгжүүлэх ХХМТГ/20192003 Багц-2 төслийн системийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хүлээнцэх актаар комисс хүлээж авсан.</p>	100%

			Комиссын ажилласан тайланг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны дотор багтаан танилцуулах Комиссын ахлагч Б.Билэгдэмбэрэл Нарийн бичгийн дарга О.Төгөлдөр			
6	2022.04.06	A/24	Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийг боловсруулах ажлын хэсэг Журмын төслийг боловсруулж, үр дүнг 2022 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн дотор танилцуулах Ажлын хэсгийн ахлагч Б.Билэгдэмбэрэл Нарийн бичгийн дарга Э.Бямбасүрэн		Төрийн энтерпрайз архитектурын тухай, ТОГАФ 9.2 стандарт зэргийг судлан төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн системийн ерөнхий зураглалыг гаргасан. Журмын төслийг боловсруулсан боловч 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан багц хуулийн хэрэгжилтийг хангах 40 гаруй журмыг боловсруулсны дараа нэгдсэн архитектурын журмын төслийг боловсруулах нь зүйтэй гэсэн саналыг ажлын хэсэг гаргасан тул энэ ажил дээр зөвлөх үйлчилгээ авахаар шийдвэрлэсэн. Үнэлэх боломжгүй.	-
7	2022.04.15	A/27	Эд хөрөнгийн тооллогын комисс Эд хөрөнгийн тооллогыг журам, зааврын дагуу 2022 оны 04 дүгээр сарын 30-ны дотор шуурхай зохион байгуулж, үр дүнг танилцуулах Комиссын ахлагч П.Дэлгэрмаа Нарийн бичгийн дарга Д.Байгалмаа	1	2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл эд хөрөнгийн тооллого хийж илтгэх хуудсаар танилцуулсан.	100%
8	2022.04.20	A/29	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.3, 20.5.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн хооронд үүссэн контент холболтын орлогын хуваарилалт, телевизийн үйлчилгээний сувгийн дараалал, үндсэн багцын үйлчилгээний орлогын хувь хэмжээний хязгаарыг тогтоохтой холбоотой асуудлыг судлан шийдвэрлэх ажлын хэсэг Ажлын хэсэг 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдөр хүртэл ажиллана. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг БТГ-ын дарга /3.Гантоого/-даалгасугай. Ажлын хэсгийн ахлагч З.Гантоого Нарийн бичгийн дарга Ч.Болор-Эрдэнэ	0	Холбогдох судалгааг хийсэн. Гишүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн ажлын хэсгээс дараах дүгнэлтийг гаргасан. Үүнд: 1.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн хооронд үүссэн контент холболтын орлого хуваарилалт, сувгийн дараалалтай холбоотой асуудлыг Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахи замаар шийдвэрлүүлэх; 2.Үндсэн багцын үйлчилгээний орлогын хувь хэмжээний хязгаарыг тогтоохтой холбоотой асуудлыг ХХЗХ-ны баталсан холбогдох журмаар зохицуулах боломжтой.	100%
9	2022.04.22	A/30	Шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журмын төслийг боловсруулах ажлын хэсэг	0	Монгол шуудан ХК, Улс хоорондын болон дотоодын шуудан, ачаа тээврийн өнөөгийн нөхцөл байдлын талаар гишүүдэд мэдээлэл өгч, журмын төсөл боловсруулах үндэслэл, шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн 2017-2021 оны орлого, зардал, солилцоонд хийсэн дүн шинжилгээ, шуудангийн үндсэн сүлжээний бүтцийн	30%

			Журмын төслийг боловсруулж, үр дунг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулах Ажлын хэсгийн ахлагч З.Гантоого Нарийн бичгийн дарга М.Солонго		талаарх бизнес загвар, Монгол Улсын 21 аймаг, 30 сумын ЗДТГ-ын шуудангийн үйлчилгээний талаарх 18 асуулт бүхий судалгааны дүнг боловсруулсан. Журмын төслийг 2 хувилбараар боловсруулсан. Сайдад танилцуулж чиглэл авахаар ажиллаж байна.	
